



2017 оны II улирлын  
“МОНГОЛБАНКНЫ ЭССЕНИЙ ТЭМЦЭЭН”-ий удирдамж

**НЭГ. СЭДЭВ: “Би нийгэмд ямар үнэ цэнийг бүтээдэг вэ?”**

**Тайлбар:**

Эдийн засагт оролцогчид (иргэд, аж ахуйн нэгжүүд, төр г.м.) нь маш олон төрлийн үйл ажиллагааг эрхэлж байдаг. Тэдгээр нь дуу дуулах, хөгжим тоглох, спортын тэмцээн уралдаанд оролцох, бизнес эрхлэх, судалгаа хийх, бодлого тодорхойлох, хоол хийх, үс засах, гэр орны ажил, амралт, хүүхэд асрах гээд олон янз байж болно. Тодорхой цаг хугацаанд эдийн засагт оролцогчид нийлбэр дүнгээрээ хэр их үнэтэй зүйл бүтээсэн бэ гэдгийг мөнгөн дүнгээр хэмжих нэг арга нь Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) юм. Гэхдээ ДНБ нь зах зээл дээр арилжаалагддаггүй зүйлсийг, мөнгөөр илэрхийлэгдэхгүй зүйлсийг хэмждэггүй г.м. онцлог бий. Харин хувь хүний бүтээсэн зүйлийн үнэ цэнийг зах зээл дээрх үнэ эсвэл цалин хөлсөөр тодорхойлдог ч, мөнгөөр илэрхийлэгдэхгүй хэсэг ч бий. Тэгвэл Та өөрийн хамгийн их зүтгэл гаргаж буй зүйлээ хэрхэн хийдгээ тайлбарлан, тэрхүү үйл ажиллагаагаараа дамжуулж нийгэмд ямар үнэ цэнийг бүтээж буй, хийдэг зүйл тань нийгэмд оруулъя гэж хүсдэг зүйлтэй чинь хэр их нийцдэг зэргийг хамруулан бичнэ үү.

**ХОЁР. ЭССЕНД ТАВИГДАХ ШААРДЛАГА**

- ✓ 800-1000 үгэнд багтаан Монгол хэлээр бичих;
- ✓ Үг үсгийн болон утга найруулгын алдаагүй байх;
- ✓ Бусдын эссег хуулбарлаагүй байх;
- ✓ Бичгийн стандарт:
  - Үсгийн фонт: Times New Roman;
  - Үсгийн хэмжээ: 12;
  - Мөр хоорондын зай: 1,5;
  - Margins: дээд захаас 20 мм, доод захаас 20 мм, зүүн захаас 30 мм, баруун захаас 15 мм.
- ✓ Нүүр хуудсанд өөрийн нэр, ажил, мэргэжил, холбоо барих 2 утас, и-мэйл хаягийг бичих;
- ✓ “Монголбанкны эссений тэмцээн” нь дээрх шаардлагыг хангасан материал илгээж буй оролцогч бүрт нээлттэй бөгөөд мэргэжил, нас, хүйс, иргэншил харгалзахгүй болно.

## ГУРАВ. ШАЛГАРУУЛАЛТ

- ✓ Тавигдаж буй шаардлагыг хангасан, өгөгдсөн сэдвийн хүрээнд бодит мэдээллийг ашиглаж, баримтаар баталгаажуулсан, энгийн ойлгомжтой, сонирхолтой байдлаар бичигдсэн эсэхийг харгалзан эхний 3 байрыг тодруулна.
- ✓ Эссег дараах шалгуураар үнэлнэ:

<b>Ерөнхий шаардлага</b>	<b>Оноо</b>
Цаг бартимтлал /18:00 цагаас хоцорсон бол -10 оноо/	10
Үгийн тоо /800-1000 үг/	5
Бичгийн стандарт /Фонт, үсгийн хэмжээ, маржин.../	5
<b>Асуултад хариулсан байдал</b>	
Өөрийн хийдэг зүйлээ тодорхойлсон байдал	10
Нийгэмд бүтээж буй өөрийн үнэ цэнийг тодорхойлсон байдал	10
<b>Эссений чанар</b>	
Үг үсгийн алдаа	5
Найруулга зүй	5
Логик дэс дараалал	10
Судалгаа/Тоо баримт ашигласан байдал	10
Энгийн ойлгомжтой байдал	10
Уншихад сонирхолтой байдал	10
Оригиналь санаа /давтагдаагүй/	10
<b>Нийт</b>	<b>100</b>

- ✓ **Шагнал:**
  - I байр: 300,000 төгрөг + Өргөмжөл
  - II байр: 200,000 төгрөг + Өргөмжөл
  - III байр: 100,000 төгрөг + Өргөмжөл
- ✓ **Хугацаа:** Тэмцээнд оролцох бүтээлийг 2017 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн 18.00 цаг хүртэл цахим хэлбэрээр [essay@mongolbank.mn](mailto:essay@mongolbank.mn) хаягаар хүлээн авна. Тэмцээний дүнг 2017 оны 5 дугаар сарын 31-нд зарлаж, шалгарсан оролцогчдод өргөмжлөл, мөнгөн шагнал гардуулна. Шалгарсан бүтээлүүдийг Монголбанкны албан ёсны вебсайт, социал сувгуудаар олон нийтэд түгээнэ.

**Бага тойруу 3, 15160, Улаанбаатар, Монголбанкны “Б” байр  
Олон нийтийн боловсрол, мэдээллийн төв  
МОНГОЛБАНК**

**Дэлгэрэнгүй мэдээллийг [www.mongolbank.mn](http://www.mongolbank.mn) веб хуудаснаас болон (976) 11-310119  
утсаар лавлана уу.**